**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/01/НА-СТА-ТЗШ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2023 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Даваанямб<br>Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Отгонбаяр<br>Утас: 88688168 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 4
**Асуудлыг онцолсон хэсэг** ..... 4
**Аудитын гол асуудал** ..... 4
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 12
**4.1 Ерөнхий зүйл** ..... 16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 17
**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 17
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ШЕЗ | Шүүхийн Ерөнхий Зөвлөл |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/97
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.АМАРТҮВШИН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын жилийн нийт төсвийн 87.5 хувийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал болон ажил олгогчийн Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

**Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны зардал өмнөх оноос 500.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Улсын Их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол гарч ажилтнуудын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 хөтөлбөр, 46 арга хэмжээний хүрээнд 71 хувийн биелэлттэй ажилласан талаар Шүүхийн Ерөнхий Зөвлөл дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,508,314.00** | **18,912,284.00** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **00.00** | **8,700,000.00** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **00.00** | **8,700,000.00** |
| 3121 | **Төгрөг** | **00.00** | **8,700,000.00** |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 00.00 | 8,700,000.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **17,508,314.00** | **10,212,284.00** |
| 354 | **Хангамжийн материал** | **13,868,314.00** | **7,037,284.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,977,644.00 | 3,513,174.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,835,670.00 | 3,074,110.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,055,000.00 | 450,000.00 |
| 35600 | Мал амьтад | 3,640,000.00 | 3,175,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **838,075,896.83** | **772,764,843.44** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **838,075,896.83** | **772,764,843.44** |
| 392 | **Биет хөрөнгө** | **754,364,396.78** | **689,303,343.35** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 579,368,577.00 | 579,368,577.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -68,724,282.60 | -98,375,196.72 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 257,913,500.00 | 257,913,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - 155,195,145.83 | -166,584,895.79 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 151,063,812.94 | 168,320,492.94 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -51,253,537.55 | -86,519,924.79 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,223,315.07 | 99,723,315.07 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -59,379,816.33 | -69,658,590.80 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,382,250.00 | 6,382,250.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,314,307.92 | -1,736,215.56 |
| 39217 | Ном | 280,032.00 | 470,032.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **83,711,500.05** | **83,461,500.09** |
| 39301 | Программ хангамж | 1,275,000.00 | 1,275,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -587,499.95 | -837,499.91 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **855,584,210.83** | **791,677,127.44** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **855,584,210.83** | **791,677,127.44** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **855,584,210.83** | **791,677,127.44** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 603,593,268.00 | 603,593,268.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 603,593,268.00 | 603,593,268.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **72,440,793.10** | **8,533,709.71** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 72,440,793.10 | 72,440,793.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -63,907,083.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 179,550,149.73 | 179,550,149.73 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **855,584,210.83** | **791,677,127.44** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,615,272,752.00** | **1,832,152,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **276,099,352.00** | **22,345,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **276,099,352.00** | **22,345,300.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 7,370,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 7,370,000.00 |
| 120009 | Бусад орлого | 2,850,000.00 | 2,320,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 272,369,264.00 | 10,076,680.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 880,088.00 | 2,578,620.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,339,173,400.00** | **1,809,807,200.00** |
| | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,339,173,400.00 | 1,804,237,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,339,173,400.00 | 1,804,237,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **5,570,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 1,070,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 4,500,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,392,064,627.96** | **1,894,559,583.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,392,064,627.96** | **1,894,559,583.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,385,222,832.58** | **1,796,298,929.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,026,280,291.84** | **1,358,260,767.00** |
| 210101 | Үндсэн цалин | 811,090,145.24 | 869,574,548.30 |
| 210102 | Нэмэгдэл | 129,389,808.00 | 382,040,790.60 |
| | Унаа хоолны хөнгөлөлт | 56,671,061.60 | 59,963,339.40 |
| 210104 | Урамшуулал | 29,129,277.00 | 46,682,088.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **134,913,486.98** | **170,440,800.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,431,359.03 | 117,539,440.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,402,031.99 | 13,263,088.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,288,025.32 | 10,570,190.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,072,006.67 | 2,642,497.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,720,063.97 | 26,425,583.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,280,025.80** | **46,671,528.80** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,197,860.00 | 6,549,189.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,454,427.80 | 35,454,427.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,627,738.00 | 4,667,912.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **68,869,209.00** | **81,968,140.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 27,429,666.00 | 32,017,470.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,033,206.00 | 24,665,675.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,327,249.00 | 13,447,592.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,500,000.00 | 1,560,000.00 |
| 210405 | Хог хаягдал устгах,цэвэрлэх | 1,242,000.00 | 1,171,350.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,337,088.00 | 9,106,052.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **800,000.00** | **677,800.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 677,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,824,670.00** | **25,927,910.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,154,670.00 | 4,927,910.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,670,000.00 | 21,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,912,800.00** | **6,702,900.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,912,800.00 | 6,702,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,390,600.00** | **15,206,350.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,475,800.00 | 11,546,750.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,794,600.00 | 2,738,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 264,700.00 | 264,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс | 346,500.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 465,000.00 | 568,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **68,951,748.96** | **90,442,733.39** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,715,000.00 | 2,785,000.00 |
| 210902 | Хичээл сургалт,үйлдвэрлэлийн дадлагын зардал | | 400,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,236,748.96 | 87,257,733.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,841,795.38** | **98,260,654.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,000,000.00** | **33,155,300.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 29,355,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 3,800,000.00 |
| | Улсын төсвөөсолгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,841,795.38 | 65,105,354.20 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,841,795.38 | 65,105,354.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **223,208,124.04** | **-62,407,083.39** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **00.00** | **1,500,000.00** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **00.00** | **-1,500,000.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **223,208,124.04** | **-63,907,083.39** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,339,173,400.00** | **1,820,307,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **10,500,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **00.00** | **10,500,000.00** |
| 120009 | Бусад орлого | | 10,500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,339,173,400.00** | **1,809,807,200.00** |
| | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,339,173,400.00 | 1,804,237,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,339,173,400.00 | 1,804,327,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **5,570,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 1,070,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 4,500,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,319,098,570.00** | **1,811,607,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,319,098,570.00** | **1,811,607,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,312,256,774.62** | **1,713,346,545.80** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,026,280,291.84** | **1,358,260,767.00** |
| 210101 | Үндсэн цалин | 811,090,145.24 | 869,574,548.30 |
| 210102 | Нэмэгдэл | 129,389,808.00 | 382,040,790.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 56,671,061.60 | 59,963,339.40 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 29,129,277.00 | 46,682,088.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **134,913,486.98** | **170,440,800.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,431,359.03 | 117,539,440.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,402,031.99 | 13,263,088.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,288,025.33 | 10,570,190.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,072,006.66 | 2,642,497.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,720,063.97 | 26,425,583.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,280,025.80** | **46,671,528.80** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,197,860.00 | 6,549,189.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,454,427.80 | 35,454,427.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,627,738.00 | 4,667,912.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **65,084,400.00** | **73,986,400.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 26,064,945.00 | 33,553,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,023,206.00 | 17,060,675.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,327,249.00 | 13,447,592.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,500,000.00 | 1,560,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,242,000.00 | 1,171,350.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,927,000.00 | 7,193,782.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **800,000.00** | **677,800.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 677,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,595,170.00** | **30,500,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,925,170.00 | 5,000,000.00 |
| 210602 | Тавилга | | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,670,000.00 | 21,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,912,800.00** | **6,702,900.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,912,800.00 | 6,702,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,390,600.00** | **15,206,350.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,475,800.00 | 11,546,750.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,794,600.00 | 2,738,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 264,700.00 | 264,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 465,000.00 | 568,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **00.00** | **10,900,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 10,500,000.00 |
| 210902 | хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 400,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,841,795.38** | **98,260,654.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,000,000.00** | **33,155,300.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 29,355,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 3,800,000.00 |
| | Улсын төвлөрсөн төсвөөс олгосон сахүүжилт, шилжүүлэг | 4,841,795.38 | 65,105,354.20 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,841,795.38 | 65,105,354.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,074,830.00** | **8,700,000.00** |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН /5/ | 20,074,830.00 | |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,074,830.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 20,074,830.00 | |
| | Биет ба биет бус хөрөнгөхудалдан авсан дүн | 20,074,830.00 | |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ /6=4-5/ | 20,074,830.00 | |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | **8,700,000.00** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **8,700,000.00** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **603,593,268.00** | **179,550,149.73** | **-150,767,330.94** | **632,376,086.79** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **603,593,268.00** | **179,550,149.73** | **-150,767,330.94** | **632,376,086.79** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 223,208,124.04 | 223,208,124.04 |
| **C08** | **2021оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **603,593,268.00** | **179,550,149.73** | **72,440,793.10** | **855,584,210.83** |
| **D01** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **603,593,268.00** | **179,550,149.73** | **72,440,793.10** | **855,584,210.83** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **603,593,268.00** | **179,550,149.73** | **72,440,793.10** | **855,584,210.83** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -63,907,083.39 | -63,907,083.39 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **603,593,268.00** | **179,550,149.73** | **8,533,709.71** | **791,677,127.44** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,804,237,200.0 | 1,739,131,845.8 | 65,105,354.2 | 96.4 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,804,237,200.0 | 1,739,131,845.8 | 65,105,354.2 | 96.4 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,772,881,900.0 | 1,707,776,545.8 | 65,105,354.2 | 96.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,406,722,800.0 | 1,358,260,767.0 | 48,462,033.0 | 96.6 |
| 210101 | Үндсэн цалин | 901,535,100.0 | 869,574,548.3 | 31,960,551.7 | 96.5 |
| 210102 | Нэмэгдэл | 441,716,300.0 | 382,040,790.6 | 59,675,509.4 | 86.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,994,000.0 | 59,963,339.4 | -26,969,339.4 | 181.7 |
| 210104 | үр дүнгийн урамшуулал | 30,477,400.0 | 46,682,088.7 | -16,204,688.7 | 153.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 175,840,300.0 | 170,440,800.0 | 5,399,500.0 | 96.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 119,571,400.0 | 117,539,440.3 | 2,031,959.7 | 98.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,067,200.0 | 13,263,088.0 | 804,112.0 | 94.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,253,800.0 | 10,570,190.2 | 683,609.8 | 93.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,813,400.0 | 2,642,497.8 | 170,902.2 | 93.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,134,500.0 | 26,425,583.7 | 1,708,916.3 | 93.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 56,900,000.0 | 46,671,528.8 | 10,228,471.2 | 82.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,200,000.0 | 6,549,189.0 | 650,811.0 | 91.0 |
| 210302 | Түлш, халаалт | 40,500,000.0 | 35,454,427.8 | 5,045,572.2 | 87.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,200,000.0 | 4,667,912.0 | 4,532,088.0 | 50.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 72,916,400.0 | 72,916,400.0 | 00.0 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 33,053,000.0 | 33,053,000.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,686,000.0 | 17,060,675.6 | -374,675.6 | 102.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,925,400.0 | 13,447,592.4 | 477,807.6 | 96.6 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,500,000.0 | 1,560,000.0 | -60,000.0 | 104.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 852,000.0 | 1,171,350.0 | -319,350.0 | 137.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,900,000.0 | 6,623,782.0 | 276,218.0 | 96.0 |
| 2105 | Нормативт зардал | 800,000.0 | 677,800.0 | | 84.7 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 800,000.0 | 677,000.0 | | 84.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 26,000,000.0 | 26,000,000.0 | 00.0 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.0 | 5,000,000.0 | 00.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 21,000,000.0 | 21,000,000.0 | 00.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,792,800.0 | 6,702,900.0 | 89,900.0 | 98.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,792,800.0 | 6,702,900.0 | 89,900.0 | 98.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,** | 16,009,600.0 | 15,206,350.0 | 803,250.0 | 95.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **үйлчилгээний төлбөр, хураамж** | | | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,350,000.0 | 11,546,750.0 | 803,250.0 | 93.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,738,900.0 | 2,738,900.0 | 00.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 264,700.0 | 264,700.0 | 00.0 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.0 | 88,000.0 | 00.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 568,000.0 | 568,000.0 | 00.0 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.0 | 00.0 | 00.0 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,900,000.0 | 10,900,000.0 | 00.0 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,500,000.0 | 10,500,000.0 | 00.0 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.0 | 400,000.0 | 00.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,355,300.0 | 31,355,300.0 | 00.0 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,355,300.0 | 31,355,300.0 | 00.0 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,355,300.0 | 29,355,300.0 | 00.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.0 | 2,000,000.0 | 00.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,804,327,200.0** | **1,739,131,845.8** | **65,105,354.2** | 96.4 |
| | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,804,327,200.0** | **1,739,131,845.8** | **65,105,354.2** | 96.4 |
| | **Улсын төсвөөс санхүүжих** | **1,804,327,200.0** | **1,739,131,845.8** | **65,105,354.2** | 96.4 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.0 | 00.0 | 00.0 | |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.0 | 00.0 | 00.0 | |
| | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 91.0 | 99.0 | -08.0 | 108.8 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 48 | 47 | 01 | 97.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 05 | 05 | 00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38 | 37 | 01 | 97.4 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05 | 05 | 00 | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,570,000.0** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,570,000.0** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,570,000.0** |

| | | |
|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,070,000.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 570,000.0 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 4,500,000.00 |
| 210602 | Тавилга | 4,500,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,570,000.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5,570,000.0** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,500,000.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчитбус этгээдээсавсан хандив, тусламж | 1,070,000.00 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.0 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.0 |
| | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 99.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 47 |
| 620001 | Удирдах ажилтан | 05 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 37 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05 |

**Төсвийн гүйцэтгэлийн тайлан / Ахмадын сан/** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 1,800,000.00 | (1,800,000.00) | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | | **1,800,000.00** | (1,800,000.00) | |
| **2132** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1,800,000.00** | (1,800,000.00) | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **1,800,000.00** | (1,800,000.00) | |
| **213209** | **Нэг удаагийн тэтгэмж урамшуулал** | | **1,800,000.00** | (1,800,000.00) | |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 10,500,000.00 | (10,500,000.00) | |
| **1200** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | 10,500,000.00 | (10,500,000.00) | |
| 120009 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 10,500,000.00 | (10,500,000.00) | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 8,700,000.00 | (8,700,000.00) | |
| | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 91.00 | 99.00 | (8.00) | 108.80 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь хүний эрх эрх чөлөө, шударга ёс, хууль ёсыг дээдлэн хамгаалах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй ил тод хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах эрхэм зорилготой ажилласан байна. Тус Шүүхийн Тамгын газар нь
шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, шүүхийн хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих, шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх, хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх, тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны тоон мэдээлэл гаргах; иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх, хуульд заасан бусад үйл ажиллагааг эрхлэн явуулдаг Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын Шүүгчийн цалин Монгол Улсын Их Хурлын 2021 он 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар шүүгчийн шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, 2 дугаар хавсралтаар шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүнийг олгох журмаар 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдсэн.

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тогтоолоор 2022 оны 5 сарын 01-ний өдрөөс Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын цалинг нэг дахин, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 193 дугаар тушаалаар шүүхийн байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 хувиар тус тус нэмэгдүүлж баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Байгууллагын удирдлага байгууллагын үйл ажиллагаа, төсөв, хөрөнгө, ажилтнуудын үйл ажиллагаатай тухай бүр танилцаж, байгууллагын нэр хүндэд хамааралтай хэвлэл мэдээллээр нэвтрүүлж буй нэвтрүүлэг, байгууллагын төсөв хөрөнгөтэй холбоотой эрсдэлтэй асуудлуудыг 7 хоног бүрийн 5 дахь өдөр шуурхай сонсголоор нэг бүрчлэн авч хэлэлцэн шийдвэрлэж хэвшсэн байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөл нь санхүүгийн дотоод аудитын албатай бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд 2 жилд нэг удаа хяналт шалгалт хийж дүгнэлт гаргаж хэрэгжилтийг эргэн шалгаж ажилладаг ба 2022 онд тус байгууллагад хяналт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ба тус баримт бичгийг удирдлага болгон ажиллаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,907.0 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 8,700.0 | -8,700.0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 17,508.3 | 10,212.3 | 7,296.0 |
| Үндсэн хөрөнгө | 838,075.9 | 772,764.8 | 65,311.1 |
| **Нийт хөрөнгө** | **855,584.2** | **791,677.1** | **63,907.0** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 855,584.2 | 791,677.1 | 63,907.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **855,584.2** | **791,677.1** | **63,907.0** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө данс өмнөх оноос өсөж, бараа материал, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- ШЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 01-ны 01/1673 тоот албан бичгээр Ахмадын санд 10500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгох шийдвэр гарснаар Хөвсгөл аймаг дахь Шүүхийн ахмадын сангийн 100170005501 дансанд 10,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 9 ахмад настанд 1,800.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт өгч, мөнгөн хөрөнгө данс 8,700.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Бараа материал дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 7,296.0 мянган төгрөгөөр буурсан нь хэргийн тоо нэмэгдэж, бичиг хэргийн болон аж ахуйн материалын өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 65,311.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 87,257.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Хөрөнгө, эх үүсвэрийн дансны өөрчлөлт нь бараа материалын дансны эцсийн үлдэгдэл буурч,

тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл өссөн, тайлант үеийн үр дүн буурсан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд өглөг, авлагагүй ажилласан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,054,900.0 мянга, нийт зарлагыг 2,054,900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 482,594.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,572,305.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа барилгын их засварын зардал, тавилга, мэдээлэл сурталчилгааны зардал, хуульд заасан процессын бусад зардлуудыг огт батлаагүй байна. Мөн эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлуудыг танаж, баталсан байна. Тайлант хугацаанд анх батлагдсан төсвийг 231,931.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,804,237.2 мянган төгрөг болгон тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 70701 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,804,237.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,804,237.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, дансны үлдэгдэл 65,105.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1739.131.8 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зарцуулаагүй үлдэгдэл 65,105.4 мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлгээр шилжүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

**/мянган төгрөгөөр/**

| д/д | Хөтөлбөр | арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | 70701-Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,767,837.2 | 1,703,531.8 | 64,305.4 | 96,36% |
| | | 80224- Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс | 4,000.0 | 3,200.0 | 800.0 | 80% |
| | | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 31,400.0 | 31,400.0 | 0 | 100% |
| | | 82321-Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал | 1,000.0 | 1,000.0 | 0 | 100% |
| | | ДҮН | 1,804,237.2 | 1,739,131.8 | 65,105.4 | 96,4% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Хөвсгөл аймгийн Гэр бүл Хүүхэд Залуучуудын хөгжлийн газраас 1000.0 мянган төгрөг, цахим тендерийн 70,0 мянган төгрөг орсон байдлыг бүртгэсэн. Мөн ШЕЗ-ийн үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс давсан орлогын 4,500,0 мянган төгрөгийн орлого орж, нэг шүүгчид тавилга авч тавилга эд хогшлын дансанд орлого авсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт Хөвсгөл аймаг дахь шүүхийн Тамгын газар нь 2022 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагчтай 5 хөтөлбөр, 46 дэд арга хэмжээ зохион байгуулахаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлтийг ШЕЗ-ийн дарга, тэргүүлэгчдээр 71 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр, гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 758,431.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,168.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн бусад бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ хязгаарлан ажиллаж, өр, авлага үүсгээгүй байна.

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэлд хяналт хийхэд зөрчил илрээгүй.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд мэдээлсэн, 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-8 дугаар зүйлийн 5 дахь заалт, Засгийн газрын 2013 оны "Босго үнэ шинэчлэн тогтоох тогтоох" тухай 68 дугаар тогтоолд нийцэхгүй тухай зөвлөмжийг хэрэгжүүлж, тайлант онд дээрх хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022.06.28-ны өдрийн 1/394 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх ноцтой асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй тул төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй тул алдаа, зөрчлийн талаар дурдаагүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: II/24

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР Д.ОТГОНБАЯР ОГНОО: 2023.02.24